

ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль анх 2003 оны 12 дугаар сарын 18-ны өдөр анх батлагдаж, одоог хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Тус хуулийн 4 дүгээр зүйлд 7 дугаар сарын 10, 11, 12, 13, 14, 15-ны өдрүүдэд Үндэсний их баяр наадам-Ардын хувьсгалын ойн баярыг, Цагаан сарыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1, 2, 3-ны өдрүүдэд, Шинэ жилийг 1 дүгээр сарын 1-ний өдөр, Олон улсын эмэгтэйчүүдийн өдрийг 3 дугаар сарын 8-нд, Хүүхдийн баярыг 6 дугаар сарын 1-ний өдөр, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярыг 12 дугаар сарын 29-ний өдөр, Их Эзэн Чингис хааны өдрийг Их Эзэн Чингис хаан мэндэлсэн билгийн тооллын өвлийн тэргүүн сарын шинийн 1-нд, Бүгд Найрамдах Улс тунхагласан өдрийг 11 дүгээр сарын 26-нд, Бурхан багшийн Их дүйчин өдрийг билгийн тооллын зуны тэргүүн сарын шинийн 15-нд тэмдэглэн өнгөрүүлэхээр тус тус тогтоосон байна.

2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийтээр амрах баярын өдөр нь долоо хоногийн амралтын өдөртэй давхацсан тохилдолд хэрхэн тэмдэглэж өнгөрүүлэх нь тодорхойгүй байх тул уг асуудлыг ойлгомжтой болгож, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд шаардлагатай зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

Тодруулбал, Цагаан сар болон Үндэсний их баяр наадмын баярын өдрүүд амралтын өдрүүдэдтэй давхцацсан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар зохицуулалтыг холбогдох хуульд тусгаж, эрх зүйн орчныг бүрдүүлэх нь зүйтэй байна.

Олон нийтийн хэлэлцүүлгийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6.4-т заасны дагуу цахим хэлбэрээр явуулахаар 2025 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр d.parliament.mn цахим хуудсанд байршуулан ажилласан.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ